



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 64

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 990,000 /есөн зуун ерэн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 330,000 /гурван зуун гучин мянга/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Samsung S8 гар утсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Ш.Энхсүх), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
64 дугаар тогтоолын хавсралт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийн Засаг даргын Тамгын газарт  
шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Гар утас	2022/03/14	ширхэг	1.00	990,000	990,000	330,000	660,000	Аймгийн ЗДТГ
<b>дүн</b>						<b>990,000</b>	<b>330,000</b>	<b>660,000</b>	